

Батлав: БОЯамны ХБОБНУГазрын Дарга  
хүлээсэн:

..... А. Энхбат

Зөвшөөрч хэрэгжүүлэх үүрэг

“Эм Кэй Вай Кашемир” ХХК-ийн  
Гүйцэтгэх Захирал .....  
Ван Жин Чуан



## “ЭМ КЭЙ ВАЙ КАШЕМИР” ХХК

### Улаанбаатар хот, Хан-Уул дүүргийн 3-р хороонд байрлах “Ноос ноолуур боловсруулах үйлдвэр” төслийн 2023 онд хэрэгжүүлэх

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ 2023

/ Регистрийн дугаар: 5579988 /

Хянасан: БОАЖЯамны ХБОБНУГазрын мэргэжилтэн .....

Боловсруулсан: “Эм Кэй Вай Кашемир” ХХК-ийн Хүний нөөц, байгаль орчны  
асуудал хариуцсан менежер .....М. Ариунжаргал

## БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

### 1. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛГО

“Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль”-д зааснаар “Эм Кэй Вай кашемир” ХХК нь үйл ажиллагаа эрхлэхдээ тухайн нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлангийн зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, үйл ажиллагаа явуулах орчинд бие болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх зорилгоор байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулан батлуулж хэрэгжилтийг хангаж ажиллах үүргийг хүлээнэ.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт, шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэнэ. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгана. Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөрт компанийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж байгаа өөрчлөлтийг хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө, зардал, хугацааг тодорхойлон тусгана.

“Эм Кэй Вай Кашемир” ХХК нь тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг жил бүрийн 12 дугаар сард багтаан БОАЖЯ-д хүргүүлж дараа оны төлөвлөгөө болон түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө, зардлын хэмжээг батлуулах үүрэгтэй.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлж ажилласнаар доорх зорилтуудыг хангана. Үүнд:

- Байгаль орчны хууль тогтоомжийн холбогдох зүйл заалт, журам заавар, стандартын шаардлагад нийцүүлэн төслийн үйл ажиллагааг явуулна.
- Байгаль орчны менежментийн асуудлаар БОННУ-ний тайланд боловсруулан тусгасан сөрөг нөлөөллийг бууруулах зөвлөмжүүдийг хэрэгжүүлнэ.
- Ажилчид байгаль орчны хамгаалах асуудалтай холбоотой үүрэг хариуцлагаа ойлгосон байх, сургалтанд хамрагдах боломжтой болно.
- Байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл, эрсдэлийг урьдчилсан тооцооноор байгальд шууд болон шууд бус хэлбэрээр үзүүлэх нөлөөллийг бууруулах, байгаль орчны төлөв байдлыг хадгалж, хамгаална.
- Сум орон нутгийн удирдлага, хяналтын байгууллага, ард иргэдтэй байгаль хамгаалах асуудлаар зөвлөлдөж, тэдний саналыг авч хамтран ажиллах нөхцөл бүрдэнэ.

### 2. Байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөө

Байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөөг Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай Монгол Улсын хууль, БОАЖЯ-аас гаргасан ерөнхий үнэлгээний дүгнэлтэд заасан шаардлагуудтай уялдуулан боловсруулсан ба тэдгээрийн хэрэгжилтийг 2022 онд хэрэгжүүлэхээр төлөвлөв. Байгаль орчныг хамгаалах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд

шаардагдах зардлыг холбогдох журам, ерөнхий үнэлгээгээр тавигдсан шаардлагын дагуу урьдчилсан байдлаар тодорхойлж тусгав. Эдгээр зардлууд нь байгаль орчныг хамгаалах ажлын шууд зардлууд бөгөөд түүнтэй холбогдон гарах бусад зураг төслийн буюу туслах чанарын ажлуудын зардал ороогүй.

БОХТ-ний биелэлтийн үр дүнгийн жил бүрийн тайланг 2022 оны 11-р сарын 01 - ний дотор БОАЖЯ-нд ирүүлж, мөн орон нутгийн засаг захиргааны байгууллага, тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаа, нутгийн оршин суугчдад танилцуулж, хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулна.

### **3. Байгаль орчныг хамгаалах, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө**

Хан-Уул дүүргийн 3-р хорооны нутаг дэвсгэрт хэрэгжиж буй “Эм Кэй Вай Кашемир” ХХК-ийн “Ноос, ноолуур боловсруулах үйлдвэр” төслөөс байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл бага эрчимтэй бөгөөд, байгалийн хам бүрдэлд үзүүлэх нөлөөллүүдээс урьдчилан сэргийлэх арилгах, бууруулах үүднээс төслийг хэрэгжүүлэхдээ 2023 онд дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхээр төлөвлөв.



**Байгаль орчныг хамгаалах, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө 2023**

| Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ   | Хамрах хүрээ                     | Хэмжих нэгж | Тоо хэмжээ          | Нэгжийн үнэлгээ, мян.төг | Нийт зардал, мян.төг | Хэрэгжүүлэгч             | Хамтран хэрэгжүүлэгч   | Биелэлтийн шалгуур  | Баримтлах хууль, журам, стандарт  |
|--|----------------------------------|-------------|---------------------|--------------------------|----------------------|--------------------------|------------------------|---|-----------------------------------|
| <b>Нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, зайлуулах, бууруулах арга хэмжээ</b>  |                                  |             |                     |                          |                      |                          |                        |   |                                   |
| “Treelings” ART’N TECH Лэнд Арт төсөлд нэгдэн “Shambala 2056 engineering campus” -д Монгол Орны цөлжилттэй бүсэд мод тарих | Хөрс, ургамлан нөмрөг            | Тоо ширхэг  | 100                 | -                        | 6 500 000            | “Эм Кэй Вай кашемир” ХХК | Төслийн хамт олон      | Ногоон байгууламжийн гэмдэглэгээ самбар, зургаар үр дүн тодорхойлох | Холбогдох хууль тогтоомжийн дагуу |
| Усны тоолуурын хэвийн ажиллагааг шалгах, засвар үйлчилгээ тогтмол хийлгэж байх   | Усны нөөц                        | 2 тоолуур   | 2                   | -                        | 200 000              | “Эм Кэй Вай кашемир” ХХК | Захиргаа               | Үр дүнгээр тодорхойлох  |                                   |
| <b>Ажилчдын эрүүл мэндэд учруулах сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ</b>                                      |                                  |             |                     |                          |                      |                          |                        |   |                                   |
| Ажилчдыг зориулалтын хувцас, бээлий, малгайгаар хангах, хангахдаа MNS 6654:2017 стандартыг баримтлах                       | Аюулгүй ажиллагаа                | Иж бүрэн    | 50 ажилчин          | 120.000                  | 6 000 000            | “Эм Кэй Вай кашемир” ХХК | Мэргэжлийн байгууллага |   | MNS 6654:2017                     |
| Ажиллагсдыг мэргэжлийн өвчнөөс урьдчилан сэргийлэх болон хугацаат эрүүл мэндийн үзлэгт хамруулах                           | Ажилчдын эрүүл мэндийг хамгаалах | Жилд 1 удаа | 35 ажилтан          | 120 000                  | 4 200 000            | “Эм Кэй Вай кашемир” ХХК | Мэргэжлийн байгууллага |   | -                                 |
| Хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэж, тухайн ажлын байранд ажиллаж буй ажилчдын эрүүл           | Ажилчдын эрүүл мэндийг хамгаалах | Тухай бүр   | Үйлдвэрл элийн алба |                          | 4 000 000            | “Эм Кэй Вай кашемир” ХХК | Мэргэжлийн байгууллага |   |                                   |

|  |                                  |               |              |        |                            |                          |                        |  |               |
|--|----------------------------------|---------------|--------------|--------|----------------------------|--------------------------|------------------------|--|---------------|
| мэндэд нөлөөлөх эрсдэлийг тодорхойлох, бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх, хянах   |                                  |               |              |        |                            |                          |                        |  |               |
| Ажилчдын эрүүл мэндийг хамгаалах хоргүйжүүлэлт хийх  | Ажилчдын эрүүл мэндийг хамгаалах | 7 хоног тутам | Нийт ажилчид | 76 000 | 3 648 000                  | “Эм Кэй Вай кашемир” ХХК | Захиргаа               |  |               |
| Ажлын байрны гэрэлтүүлгийг жигд хүрэлцээтэй тусаж байхаар ерөнхий болон хэсгийн гэрэлтүүлгийг сайжруулах   | Аюулгүй ажиллагаа                | 1 удаа        | 50 ш         | 10 000 | 500 000                    | “Эм Кэй Вай кашемир” ХХК | Мэргэжлийн байгууллага | АҮК өндөртэй, байгаль орчинд ээлтэй тоног төхөөрөмж сонгох | MNS 4996:2000 |
| Үйлдвэрлэлийн эрүүл ахуй, хөдөлмөрийн нөхцөл, түүний ангилал, хүчин зүйл, хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ MNS 5080:2001” стандартыг мөрдөж ажиллах | Хөдөлмөрийн аюулгүй байдал       | Тогтмол       | -            | -      | Зардал тусгах шаардлагагүй | “Эм Кэй Вай кашемир” ХХК |                        |  | MNS 5080:2001 |
| <b>Нийт</b>  |                                  |               |              |        |                            |                          | <b>25,048,000</b>      |  |               |




**i. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө**

| Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл, өртөгч     | Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ  | Арга хэмжээн ий цар, хэмжээ | Тоо хэмжээ (5 жилээр) | Нэгж зардал (.төг) | Нийт зардал (.төг) | Хэрэгжүүлэгч             | Хамтран хэрэгжүүлэгч   | Биелэлтийн шалгуур        | Баримтлах хууль журам, стандарт, аргачлал |
|---|--|-----------------------------|-----------------------|--------------------|--------------------|--------------------------|------------------------|---------------------------|---|
| <b>Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө</b> |  |                             |                       |                    |                    |                          |                        |                           |   |
| Хатуу хог хаягдал                           | Хатуу хог хаягдлын түр цэгээ сайжруулах  | Үйлдвэрийн хашаанд          | 1 ш/удаа              | -                  | 300 000            | “Эм Кэй Вай кашемир” ХХК |                        |                           | “Хог хаягдлын тухай хууль”                |
|   | Гадаад талбайд хог хаягдлыг ангилан ялгаж хаях боломжтой хогийн савыг засварлах, солих         | Үйлдвэрийн хашаанд          | 3 ш                   | 50 000             | 150 000            | “Эм Кэй Вай кашемир” ХХК |                        |                           |   |
|   | Үйлдвэрийн талбай дахь хог хаягдлыг цэвэрлэж, эдэлбэр газрын ашиглалтыг сайжруулах             | Үйлдвэрийн хашаанд          | 3 удаа                | -                  | 180 000            | “Эм Кэй Вай кашемир” ХХК |                        | Талбайн зохион байгуулалт |   |
| Удаан задардаг хатуу хог хаягдал үүсэх      | Дахин боловсруулагдах хог хаягдлыг хоёрдогч түүхий эд авах байгууллага, нэгжид нийлүүлэх       | Төслийн хүрээнд             | 3 удаа                | -                  | 300 000            | “Эм Кэй Вай кашемир” ХХК | Гэрээ байгуулж ажиллах |                           |   |
| Ялаа шавж үржих, өвчин гарах                | Хог хаягдлын цэгт ариутгал, халдваргүйжүүлэлтийг тогтмол хийх, орчныг бохирдуулахаас сэргийлэх | Хатуу хог хаягдлын цэгт     | Сар бүр 1 удаа        | 55 000             | 495 000            | “Эм Кэй Вай кашемир” ХХК |                        |                           |   |

|  |   |                 |         |  |                          |  |                    |  |
|--|---|-----------------|---------|--|--------------------------|--|--------------------|--|
| Ахуйн хатуу хог хаягдал орчныг бохирдуулах | Хог түр хадгалах цэгт цугларсан хогийг тогтмол хугацаанд зөвшөөрсөн цэгт тээвэрлүүлж байх | Төслийн хүрээнд | Тогтмол | Холбогдох байгууллагатай хийсэн гэрээнд заасан төлбөрийн хэмжээгээр. | “Эм Кэй Вай кашемир” ХХК |  | Хог хаягдлын гэрээ | “Хог хаягдлын тухай хууль” MNS 5344:2003 |
| <b>Нийт</b>                                |   |                 |         | <b>1.425.000</b>   |                          |  |                    |  |

**ii. Удирдлага-зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөө**

| Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл, өртөгч  | Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ       | Арга хэмжээний цар, хэмжээ | Тоо хэмжээ (5 жилээр) | Нэгж зардал (.төг)                  | Нийт зардал (.төг) | Хэрэгжүүлэгч             | Хамтран хэрэгжүүлэгч                      | Биелэлтийн шалгуур                      | Баримтлах хууль журам, стандарт, аргачлал        |
|--|--|----------------------------|-----------------------|-------------------------------------|--------------------|--------------------------|---|---|--|
| <b>Байгаль орчны удирдлага-зохион байгуулалтын арга хэмжээ</b>   |  |                            |                       |                                     |                    |                          |   |   |  |
| Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулж жил бүр батлуулж байх   |  | Төслийн хүрээнд            | Жил бүр               | -                                   |                    | “Эм Кэй Вай кашемир” ХХК |   | БОМТ-ний тайлан                         |  |
| Ажилчдын дунд байгаль хамгаалах талаар сургалт, сурталчилгааны ажлыг тогтмол зохион байгуулах<br>- Байгаль орчныг хамгаалах<br>- Гал түймрээс урьдчилан сэргийлэх /шаардлагатай үед гал унтраах багаж хэрэгслийг ашиглаж чаддаг байх/<br>- Хөдөлмөр хамгаалал<br>- Тогтвортой хөгжлийн зорилтуудыг танилцуулах зэрэг сэдвээр |  | Бүх ажилчид                | Жилд 2 удаа           | 500 000                             | 1 000 000          | “Эм Кэй Вай кашемир” ХХК | Байгаль орчны мэргэжилтний оролцоотойгоор | Сургалтанд хамрагдсан бүртгэл тэмдэглэл |  |
| Газар, ус, цахилгаан ашигласны болон бусад төлбөрийг төлөх   |  | Төсөвт хувь нэмэр оруулах  | 5 багц                | Үйл ажиллагааны зардалд тусгагдана. |                    | “Эм Кэй Вай кашемир” ХХК |   |   | Байгалийн нөөц ашигласны тухай хууль болон бусад |
| Эрүүл мэндийг хамгаалах  | Ажлын байрны эмийн санг сэлбэх, сайжруулах | Иж бүрэн                   | 3                     | 100 000                             | 300 000            | “Эм Кэй Вай кашемир” ХХК |   |   |  |



|  |   |          |   |  |                          |  |  |  |
|--|---|----------|---|--|--------------------------|--|--|--|
| Дүүргийн байгаль хамгаалах албатай хамтран байгаль хамгааллын систем байгуулан ажиллах | Төслийн үйл ажиллагаатай холбогдуулан дүүргийн болон хорооны холбогдох төр захиргааны байгууллагтай хамтран ажиллах | Иж бүрэн | 1 | Тухайн үеийн үйл ажиллагааны зардалд тусгагдана. | “Эм Кэй Вай кашемир” ХХК |  |  |  |
| <b>Нийт</b>  |   |          |   |  | <b>1 300 000</b>         |  |  |  |



iii. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах арга хэмжээний төлөвлөгөө

| Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах арга хэмжээ |                                      |  |                         |   |                              |                          |   |
|---|--------------------------------------|--|-------------------------|---|------------------------------|--------------------------|---|
| БОМТ хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд                                    | Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр        | Мэдээллийн агуулга                                 | Хугацааны тов           | Хэлэлцүүлгээр санал авах чиглэл   | Зохион байгуулах газар       | Хэрэгжүүлэгч             |   |
| Нийслэлийн байгаль орчны газар  | Шинжээчдийн дүгнэлтээр баталгаажна.  | Тухайн жилийн БОМТ-ний биелэлтийн тайлан           | Жил бүрийн 11-р сарын 1 | Шинжээчдийн дүгнэлт   | Дүүргийн байгаль орчны газар | “Эм Кэй Вай кашемир” ХХК | “БОНХЯ-ны сайдын 2014 оны 1-р сарын 06-ны өдрийн А-03 тоот журам”<br>Олон нийтийн оролцоо, хяналтыг хэрэгжүүлэх хүрээнд |
| Бүх шатны Засаг дарга, Байгаль орчны улсын байцаагч, орон нутгийн байцаагч                | Хуралд танилцуулах, Уулзалт          | БОМТ-ийн тухайн жилийн тайлан, Ирэх оны төлөвлөгөө | 12-р сарын 1-ний дотор  | БОХ арга хэмжээний тайлан ирэх оны төлөвлөгөөг танилцуулах, санал авах, хамтран ажиллах | Дүүрэг, хороо                | “Эм Кэй Вай кашемир” ХХК |   |
| Төрийн бус байгууллага, олон нийт   |                                      |  | Жил бүр 1 удаа          |   | Тухайн үед сонгох            | “Эм Кэй Вай кашемир” ХХК |   |
| Төрийн захиргааны төв байгууллага   | Тайлан, төлөвлөгөөг цаасан хэлбэрээр |  | 12-р сарын 10-ний дотор | Хянуулах баглуулах  | Улаанбаатар хот              | “Эм Кэй Вай кашемир” ХХК |   |



## Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

“Эм Кэй Вай кашемир” ХХК-ийн Ноос, ноолуур боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийн цар хүрээ, эрчмийг харгалзан үзэж, түүний нөлөөллийн бүсийн талбайг хамруулан байгаль орчны хяналт шинжилгээний мониторингийн системийг байгуулах нь зүйтэй.

Тухайн төслийг хэрэгжүүлснээс үүдэн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг тухай бүр илрүүлэх, бууруулах, арилгах зорилгоор байгаль орчны төлөв байдал, шинээр үүсэн бий болсон нөхцөл байдалд ажиглалт, хяналт явуулах үйл ажиллагааны удирдамжийг “орчны хяналт шинжилгээний хөтөлбөр” /ОХШХ/ гэнэ. Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөр нь төслийг хэрэгжүүлэх явцад үүссэн сөрөг нөлөөлөл, түүнийг бууруулах үйл ажиллагаа ямар үр дүнтэй байгааг илтгэх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний үндэслэлийг боловсруулах, орон нутгийн захиргаа болон нутгийн оршин суугчдад бодитой мэдээлэл өгөхөд чухал ач холбогдолтой.

### *Агаар орчин*

ОХШХ-г тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэх, сорьцын шинжилгээний төрөл хэлбэрийг хөтөлбөрт тусгагдсаны дагуу графикт хугацаанд нь хийлгэж, дүгнэлт гаргуулж байх, шаардлагатай тохиолдолд холбогдох арга хэмжээг авна. Хийн бохирдлын менежмент нь хүний эрүүл мэндийг хамгаалах, амрагч сувилуулагч, ажилчид, нутгийн оршин суугчдын ажиллах, амьдрах таатай нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн байх ёстой буюу төлөвлөлтийн холбогдох үндсэн шалгуурууд агаарт хаяж буй бохирдуулагчдад тавигдах ёстой.

### *Усны чанар*

Усны чанарын шинжилгээг төсөл хэрэгжих хугацаанд хийлгэх хяналт шинжилгээг графикт хугацаанд нь шинжилгээ хийлгэж, дүгнэлт гаргуулан, бохирдол илэрсэн тохиолдолд мэргэжлийн байгууллагатай хамтран түүнийг арилгах арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай.

### *Хөрсөн бүрхэвч*

Хөрсний бохирдлын түвшинг дотоодын магадлан итгэмжлэгдсэн лабораториор гүйцэтгүүлэх, хяналт шинжилгээний хөтөлбөрт тогтоосон сорьц авах цэгүүд дээр үргэлжлүүлэх, сорьцын шинжилгээний төрөл хэлбэрийг орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгагдсаны дагуу графикт хугацаанд нь хийлгэж дүгнэлт гаргуулж байх.

**Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардал:**

| №                                  | Хяналт шинжилгээ хийх үзүүлэлт   | Хэмжих нэгж                 | Байршил  | Хугацаа ба давтамж   | Нэгж зардал (мян.төг) | Нийт зардал (мян.төг) | Хэрэгжүүлэгч             | Хамтран хэрэгжүүлэгч  | Баримтлах стандарт   |
|------------------------------------|--|-----------------------------|--|----------------------|-----------------------|-----------------------|--------------------------|---|--|
| <b>1. АГААРЫН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ</b> |  |                             |  |                      |                       |                       |                          |   |  |
| 1.1.                               | Хорт хийн агууламж:<br>Азотын давхар исэл (NO <sub>2</sub> )<br>Хүхэрлэг хий (SO <sub>2</sub> )<br>Нүүрстөрөгчийн дутуу исэл (CO <sub>2</sub> ), CO, HCN, O <sub>2</sub> . | мкг/м <sup>3</sup>          | Хатуу хог хаягдлын цэгийн ойролцоо болон ногоон байгууламжийн ойролцоо 1 цэг | Жилд 1 удаа (7 сард) | 400 000               | 400 000               | “Эм Кэй Вай кашемир” ХХК | Мэргэжлийн байгууллага, судлаач   | MNS 4585:2016<br>MNS 3384:1982<br>MNS 4048:1988<br>MNS 0017-2-5-11:1988<br>MNS 5013:2009<br>MNS 5014:2009<br>MNS 5002:2000 |
| 1.2.                               | Агаарын тоос тоосонцор (PM <sub>2.5</sub> , PM <sub>10</sub> )   | мкм                         | Бохирдол үүсэх эх үүсвэр орчимд 1 цэгээс дээж авах                           |                      |                       |                       |                          |   |  |
| <b>2. УСНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ</b>    |  |                             |  |                      |                       |                       |                          |   |  |
| 2.1.                               | Усны химийн шинжилгээ<br>Био идэвхит нэгдлүүд<br>Нян судлалын үзүүлэлт:  | мг/дм <sup>3</sup>          | Гүний худаг  | Жилд 1 удаа          | 100 000               | 100 000               | “Эм Кэй Вай кашемир” ХХК | Газарзүй, Гео-экологийн хүрээлэнгийн усны лаборатори, Ус цаг уур орчны шинжилгээний газар | MNS (ISO) 5667-1:2002<br>MNS (ISO) 5667-2:2002:<br>MNS 4867-1999:<br>УСТ-3534-1983<br>MNS 0900:2005<br>MNS 4685:1998       |
|                                    |  | 1 мл-т илрүүлэх<br>100 мл-т |  |                      |                       |                       |                          |   |  |
| 2.2.                               | Ноос, ноолуур боловсруулах үйлдвэрүүдээс ариутгах татуургын төвлөрсөн сүлжээнд   | мг/л                        | Төвлөрсөн сүлжээнд нийлүүлж буй ус   | Жилд 2 удаа          | 200 000               | 400 000               | “Эм Кэй Вай кашемир” ХХК | Итгэмжлэгдсэн лабораториуд  | MNS 6390:2013  |



| №  | Хяналт шинжилгээ хийх үзүүлэлт  | Хэмжих нэгж | Байршил  | Хугацаа ба давтамж | Нэгж зардал (мян.төг) | Нийт зардал (мян.төг) | Хэрэгжүүлэгч             | Хамтран хэрэгжүүлэгч   | Баримтлах стандарт   |
|--|---|-------------|--|--------------------|-----------------------|-----------------------|--------------------------|--|--|
|  | нийлүүлэх урьдчилан цэвэршүүлсэн бохир ус   |             |  |                    |                       |                       |                          |  |  |
| <b>ХӨРСНИЙ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ</b>                |   |             |  |                    |                       |                       |                          |  |  |
| 3.1.   | Хөрсний физик, агрохимийн үндсэн үзүүлэлтүүд:<br>Хөрсний морфологи бичиглэл, рН, цахилгаан дамжуулалт, давс %, ялзмагийн агууламж %, шим тэжээлийн элемент (NO <sub>3</sub> , P <sub>2</sub> O <sub>5</sub> , K <sub>2</sub> O) | мг          | Ногоон байгууламжийн ойролцоо                        | Жилд 1 удаа        | -                     | 100 000               | “Эм Кэй Вай кашемир” ХХК | Газарзүй, Гео-экологийн хүрээлэнгийн Хөрс судлалын лаборатори, Магадлан итгэмжлэгдсэн хөрсний лабораториуд | MNS 3298:1991<br>MNS 5850:2008<br>MNS 3985-87<br>MNS 3310-91<br>MNS 2305-94<br>MNS 2305:1994 |
| 3.2.   | Хөрсний хүнд элементүүд /Pb, Cr, Cd, Ni, Co/  |             | Хатуу хог хаягдлын цэг эсвэл авто зогсоолын ойролцоо | Жилд 2 удаа        | -                     | 200 000               | “Эм Кэй Вай кашемир” ХХК |  |  |
| <b>ЭРҮҮЛ АХУЙН ХЯНАЛТ</b>                      |   |             |  |                    |                       |                       |                          |  |  |
| 4  | Дуу шуугиан   | дБА         | Үйлдвэрийн талбай орчимд                             | Жилд 1 удаа        | -                     | 400 000               | “Эм Кэй Вай кашемир” ХХК | Хорооны эрүүл мэндийн байгууллага  | MNS 5002:2000<br>MNS ISO 226:2003  |
| <b>1 жилийн ОХШХ-ийн нийт зардал /мян.төг/</b> |   |             |  |                    |                       | <b>1.600.0000</b>     |                          |  |  |



“Эм Кэй Вай Кашемир” ХХК-ийн “Ноос, ноолуур боловсруулах үйлдвэр”  
Байгаль орчны менежментийн төлөвлөгөө 2023

**Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардлын хураангуй:**

| №   | Зарцуулах зардлын зориулалт                  |   | Зардлын задаргаа  |                           |
|---|--|---|---|---------------------------|
| 1   | Байгаль орныг хамгаалах төлөвлөгөө           | a | Нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, зайлуулах, бууруулах арга хэмжээ, ногоон байгууламж орчны тохижилт хийх | 6 700 000 мян.төг         |
|   |  | b | Ажилчдын эрүүл мэндэд учруулах сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ                          | 18 348 000 мян.төг        |
|   |  | c | Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө  | 1 425 000 мян.төг         |
|   |  | d | Байгаль орчны удирдлага-зохион байгуулалтын арга хэмжээ   | 1 300 000 мян.төг         |
|   |  | e | Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах арга хэмжээ               | 0 мян. төг                |
| <b>Нийт</b>   |  |   |   | <b>27 773 000 мян.төг</b> |
| 2   | Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардал | a | Агаарын хяналт шинжилгээ  | 400 000 мян. төг          |
|   |  | b | Усны хяналт шинжилгээ   | 500 000 мян. төг          |
|   |  | c | Хөрсний хяналт шинжилгээ  | 300 000 мян. төг          |
|   |  | d | Эрүүл ахуйн хяналт  | 400 000 мян. төг          |
| <b>Нийт</b>   |  |   |   | <b>1 600 000 мян.төг</b>  |
| <b>Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал</b> |  |   |   | <b>29 373 000 мян.төг</b> |